



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/60

Шивээговь сум

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны ёс зүйн дүрэм” А/545 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нартай холбоотой ёс зүйн зөрчлийн гомдол мэдээлэл хүлээн авч хянан үзэж, хэлэлцэн шийдвэрлэх эрх бүхий ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- Зөвлөлийн дарга: (Засаг даргын Тамгын газрын дарга)
- Гишүүн: (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
- Б.Базаррагчаа
- (Сургуулийн эцэг эхийн төлөөлөл)
- Н.Амаржаргал
- (Цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл)
- Нарийн бичгийн дарга: М.Гантуяа
- (Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Ёс зүйг зөрчлийн тухай гомдол мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлж баримт нотолгоонд үндэслэн шалгаж, гомдолыг барагдуулах, ажлыг зохих журмын дагуу шийдвэрлэн дүгнэж, идэвхи санаачлагатай ажиллахыг зөвлөлийн гишүүдэд эргэн мэдээлж тайлагнахыг зөвлөлийн дарга нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг бологсугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ

